



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН 2024



АГУУЛГА

- УДИРТГАЛ
- ТУЗ-ЫН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ
- БИДНИЙ ТУХАЙ
- ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
- БАЙГАЛЬ ОРЧИН
- НИЙГЭМ
- ЗАСАГЛАЛ

ТАЙЛАНГИЙН УДИРТГАЛ

“Эм Жи Эл Акуа” ХК нь олон нийтэд тогтвортой хөгжил байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) тайлангаа нээлттэй танилцуулж буйд баяртай байна. Тайлангаар бид үйл ажиллагаандаа байгаль дэлхийд ээлтэй, ил тод, сайн засаглалтай, бүтээгдэхүүн үйлдвэрлэл үйлчилгээгээрээ хариуцлагатай бизнесийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, оролцогч талуудын ил тод байдлыг хангах, олон улсын аргачлалын дагуу тооцож тайлагнах үүргийн дагуу ажиллаа.

Тайлагнах зарчим

“Тайлагналын Олон Улсын Санаачилга” (GRI), НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилтууд” Bloomberg, БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж 2022, SASB бусад хувьцаат компанийн тогтвортой байдлын тайланг загвар жишээ болгон ашигласан.



МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, харилцагч, бизнесийн хамтрагч, ажилтан Та бүхэнд “Эм Жи Эл Акуа” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнөөс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлэн 2024 оны “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН”-гаа танилцуулж байна.

2024 он “Эм Жи Эл Акуа” ХК-ийн хувьд хөгжил дэвшил бүхий түүхэн жил байлаа. Voyage брэнд нь нийт цэвэр усны зах зээлийн 43%-ийг дангаар эзэлж түүхэн дэх хамгийн өндөр зах зээлийн тэлэлтээ хийж байна.

“Эм Жи Эл Акуа” ХК нь Монгол Улсын хөгжилд бодитой хувь нэмэр оруулах зорилгын хүрээнд бизнесийн үйл ажиллагаагаа НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудтай уялдуулан байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

Хамтын удирдлага, хамтын өсөлт, сайн засаглал, тогтвортой хөгжлийн төлөө хамтдаа байгаа та бүхэндээ баярлалаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
С.АЛТАНТУЯА

БИДНИЙ ТУХАЙ

АЛСЫН ХАРАА



Экологийн тэнцвэрийг
хамгаалан өвлүүлж, бүс
нутагтаа
хариуцлагатайгаар
бизнесээр тэргүүлнэ.



2 төрлийн
бүтээгдэхүүн
6 төрлийн савлагаа

ЭРХЭМ ЗОРИЛГО



Байгалийн гүний цэнгэг
усыг дэвшилтэт
технологи, хүнсний
үйлдвэрлэлийн олон
улсын стандартаар
үйлдвэрлэж, хэрэглэгч
бүртээ хүргэн, оролцогч
талуудынхаа сонирхолд
нийцсэн хариуцлагатай
үйл ажиллагааг
компанийн сайн
засаглал, тогтвортой
хөгжлийн үзэл
баримтлалд нийцүүлэн
явуулна.



192 ажлын байр



5500 харилцагч



Орон нутаг
гэрээт 58 харилцагч

ҮНЭТ ЗҮЙЛС



Чанартай бүтээгдэхүүн
Чадварлаг ажилтан
Тогтвортой харилцагч
Үнэнч хэрэглэгч



Өдөрт нэг машин
1500 км туулна

БҮТЭЭГДЭХҮҮН

Цэвэр ус - 6 төрлийн савлагаа IC



Бумбатын рашааны судлаас эхтэй 120 метрийн гүний усыг 6 дамжлага бүхий RO шүүлтүүрээр шүүн цэвэршүүлж Монгол Улсын савласан усны MNS 5007:2022 стандартад бүрэн нийцүүлэн үйлдвэрлэдэг ба бүтээгдэхүүнүүд маань хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан 100% чанартай бүтээгдэхүүн байдаг.

Шүлтлэг ус pH 8.5 - 2 төрлийн савлагаа FC



Voyage pH 8.5 шүлтлэг ус нь эрүүл, тэнцвэртэй хооллолтыг дэмжих зорилгоор байгалийн цэвэршүүлсэн хужраар баяжуулж зөөлрүүлсэн эрүүл мэндийн ач холбогдолтой шүлтлэг ус юм. Уг ус нь хүний биед шаардлагатай шингэний хэрэгцээг хангаас гадна цээж хорсолтыг дарах, ходоодны хүчлийг саармагжуулахад тустай эрүүл мэндийн ус юм.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН НИЙЦҮҮЛЭЛТ

- Тогтвортой хөгжил ба бидний оролцоо
- Тогтвортой хөгжлийн удирдлага
- Тогтвортой хөгжлийн журмууд



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО



Жилд нэг удаа ажилтнуудынхаа эрүүл мэндэд анхаарч эрүүл мэндийн урьдчилан сэргийлдэг үзлэгт хамруулдаг.




Хүн бүрд цэвэр ус хүртээмжтэй байлгахыг зорьж боломжийн үнээр, чанартай усаар хангахад бид бодитой хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



Хог хаягдлыг бууруулахад өөрсдийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал хуванцар сав болон бусад хогийг дахин боловсруулалтад оруулдаг.



Жилд бүр ажилтнуудынхаа сурч хөгжих, карьерын өсөлт хөгжилтийг сайжруулах зорилгоор ерөнхий болон мэргэжлийн, олон улсын болон дотоодын сургалт, арга хэмжээнд тогтмол хамруулдаг.



205 ажлын байрыг бий болгон, өрсөлдөхүйц цалин урамшууллыг бий болгож ажилладаг.



Хэрэглэсэн усныхаа савыг дахин боловсруулалтад оруулахыг иргэдэд уриалж тэдний оролцоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна.



Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс, удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон боловсрол, албан тушаалаас үл хамааран эрх тэгш оролцох боломжоор хангаж ажилладаг.



Хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх, эрх тэгш байдлыг цогцлоох, хангах, үнэлэх хууль эрх зүйн орчин бүрдүүлж ажилладаг.



Монгол Улсын хууль дүрэм журмыг баримталж ажилладаг.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА

Төлөөлөн удирдах зөвлөл

Тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлох урт хугацааны стратеги төлөвлөгөөг гаргах.

Гүйцэтгэх удирдлага

Тогтвортой хөгжлийн зарчмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөж, хяналт тавьж, мэдээллийн нэгтгэн өөрийн хариуцсан хэлтэс, албаны үйл ажиллагааны тогтвортой хөгжилд хамаарах тайланг гарган ажиллана.



Тогтвортой хөгжлийн хороо

- Аудит эрсдэлийн хороо
- Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо
- Стратеги бизнес хөгжлийн хороо
- Хөрөнгө оруулагчдын харилцааны хороо

Дунд түвшний удирдлагууд

Тогтвортой хөгжлийн зарчмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөж, хяналт тавьж, мэдээллийн нэгтгэн өөрийн хариуцсан хэлтэс, албаны үйл ажиллагааны тогтвортой хөгжилд хамаарах тайланг гарган ажиллана.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Бодлого, зохицуулалтын төлөвлөлт **2025**

Байгаль орчин

- Байгаль орчин хамгааллын бодлого
- Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэлтийн бодлого
- Усны нөөцийн ашиглалт хамгаалалтын журам
- Хог хаягдлын менежментийн журам
- Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, хэрэглээний хүлэмжийн хий бууруулах журам

Нийгэм

- Хандив тусламжийн бодлого
- Олон янз байдал тэгш боломжийн бодлого
- Олон талт оролцогч талуудтай хамтран ажиллах журам
- Хөдөлмөрийн эрх зүйн бодлого

Засаглал

- Хариуцлагатай маркетингийн бодлого
- Нийгмийн хариуцлагын бодлого
- Тогтвортой ханган нийлүүлэлтийн бодлого
- Ёс зүйн дүрэм, журам
- Шударга өрсөлдөөний бодлого
- Эрсдэлийн удирдлагын журам
- Ил тод мэдээллийн хүртээмжийн журам
- Тогтвортой санхүүжилтийн журам

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЖУРАМ



- Авлига хээл, хахуулын эсрэг журам



- Тогтвортой ханган нийлүүлэлтийн бодлого журам



- Ажилтны ёс зүйн дүрэм, журам



- Санал гомдол хүлээн авах журам



- Эрсдэлийн удирдлагын журам



- Сургалт хөгжлийн журам



- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэгш боломж олгох журам



- Жендерийн тэгш байдлыг хангах журам

БАЙГАЛЬ ОРЧИН

- Тогтвортой хөгжлийн зорилт
- Байгаль орчны гүйцэтгэл
- Хуруу савны жин бууруулалт
- Тойрог эдийн засгийн шилжилт

БАЙГАЛЬ ОРЧИН

2024 оны

голлох үзүүлэлтүүд



Цэвэршүүлсэн хаягдал усны эргүүлэн ашигласан хэмжээ **2%**



Хуванцар савлагааны жинг **1.5** граммаар бууруулсан



Тооллогын **стандарт аргачлал** (GHG Protocol, ISO 14064) ашиглан хүлэмжийн хийн тооллого хийлэгсэн



Хуванцар болон гялгар хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн **10%**

2030 оны

зорилт



Ус шүүгч болон тоног төхөөрөмжөөс гарах цэвэрлэгээний усыг **100%** эргүүлэн ашиглана.



Хүлэмжийн хийн ялгаралыг жил бүр бууруулах бодлого баримтална



Байгалийн нөөцийг зохистой ашиглан “Voyage” брэнд бүтээгдэхүүн дээр “Эко” тэмдэгжүүлэлд баталгаажуулалт авна.



Хог хаягдлыг дахин боловсруулах түвшинг **40%** хүргэх замаар байгаль орчны тогтвортой байдлыг хангана.

2024 ОНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Эдийн засгийн ногоон шилжилт

Монгол Улсад анх удаа шингэн хүнсэнд “Эко тэмдэг” олгох “Эдийн засгийн ногоон шилжилт” төсөлд оролцохоор сонгогдов.



Хүлэмжийн хийн тооллого

Үйлдвэрлэлийн үйл явцаас ялгарах хүлэмжийн хийн хэмжээг [GHG Protocol] аргачлалаар тооцоолон гаргасан нь цаашид хүлэмжийн хийн ялгарлыг тогтмол хянах, бууруулах үйл ажиллагаанд чухал түлхэц болсон.



Дулааны эх үүсвэрийн шинэчлэл

Сайжруулсан дулаан хадгалалттай бага түлш зарцуулж их дулаан, Хүлэмжийн хий бага ялгаруулдаг байгаль орчинд сөрөг нөлөө багатай нүүрсэн шүүлтүүртэй усан халаалтын уурын зуух ашиглалтад оруулснаар түлшний хэрэглээг **5%** бууруулсан.




Тойрог эдийн засгийн түншлэл

Хаягдал хуванцар, гялгар, бөглөөг үр ашигтайгаар цуглуулж, дахин боловсруулах үйлдвэр “ТЖТБ” нийлүүлснээр байгаль орчны бохирдлыг бууруулж, нөөцийн дахин ашиглалтыг **10%** нэмэгдүүлсэн.



ХУРУУ САВНЫ ЖИН БУУРУУЛАЛТ



Нэг хуруу савны жинг 2 граммаар бууруулснаар **26 тонн** хуванцар материал хэмнэгдэж, ойролцоогоор **6 тонн хүлэмжийн** хийн ялгарлыг бууруулсантай тэнцэнэ.

БӨГЛӨӨНИЙ ЖИН БУУРУУЛАЛТ



2.4гр → 2.1гр

Нэг бөглөө үйлдвэрлэлийг 0.3 граммаар бууруулснаар **3 тонн** хуванцар хэмнэж, байгаль орчны хаягдлыг бууруулан, тогтвортой хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан.

Voyage



БАЙРТАЙ БӨГЛӨӨ

“Байртай бөглөө” хөтөлбөрөөр дамжуулан уусан усныхаа бөглөөг цуглуулах зорилгод хэрэглэгчдийг нэгтгэж хуванцар бөглөө байгальд хаягдахаас урьдчилан сэргийлж, 1.3 тонн бөглөө буцаан цуглуулан хэрэглэгчдийг хуванцар хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулалтад хувь нэмэр оруулахыг уриалав.

Түүнчлэн тус хөтөлбөрийн супер бэлгийн хоёр азтан тус бүрт хоёр өрөө байр бэлэглэж, агаарын бохирдлын эсрэг хувь нэмрээ оруулахаар зорьсон.

1,3 тонн бөглөө буцаан
цуглуулав.



НИЙГЭМ

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО

A

ДОТООД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

- Удирдлага
- Менежментийн баг
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Үйлдвэрийн операторууд
- Лабораторийн ажилтнууд
- Борлуулалт, маркетингийн ажилтнууд
- Ложистик, түгээлтийн ажилтнууд
- Хүний нөөцийн ажилтнууд
- Санхүүгийн ажилтнууд
- Гэрээт ажилчид

B

ГАДААД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

- Харилцагчид
- Нийлүүлэгчид
- Засгийн газар ба зохицуулах байгууллагууд
- Орон нутгийн иргэд, нийгэм
- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд
- Банк, хөрөнгө оруулагчид

C

ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ АРГА ЗАМУУД

- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Ажилчдын уулзалт, санал асуулга
- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа
- Нийлүүлэгчтэй хамтын ажиллагааны уулзалт
- Нийгмийн хариуцлагын тайлан, мэдээллийн ил тод байдал
- Хэвлэл мэдээллийн мэдэгдэл, нийтлэл
- Орон нутгийн оролцогч талуудтай уулзалт, нээлттэй өдөрлөг



НИЙГМИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ



Хүний эрхийг дээдлэх



Ажилчдын оролцоо сэтгэл
ханамжийг чухалчлан үздэг.



Ажилчдын цаашид өсөж дэвжих, шинэ
ур чадварт суралцах боломжийг нээдэг.




Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын
стандартуудыг дагаж мөрдөн хэрэгжүүлдэг.



Үйлчлүүлэгч, харилцагчийн хувийн мэдээллийг
чандлан нууцлах бодлого баримталдаг.

АЖЛЫН БАЙРНЫ ХҮРТЭЭМЖ



Үйлдвэрлэл	45
Захиргаа, хүний нөөц	5
Борлуулалт	52
Чанар хяналт	5

ХАБЭА	1
Түгээлт	74
Ашиглалт, үйлчилгээ хангамж	15
Маркетинг	3



СУРГАЛТ ХӨГЖИЛ, ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭЛТ

31

Удаагийн сургалт

22

Гадаад сургалт

9

Дотоод сургалт

ГАДААД СУРГАЛТ

Олон улсын стандарт
Борлуулалтын ур чадвар
Удирдах ажилтны ур чадвар

 **990**
ЦАГ

ДОТООД СУРГАЛТ

Ажилтнуудын ёс зүй
Ажлын ур чадвар дээшлүүлэх
Харилцаа хандлага
Байгууллагын дүрэм журмын
хэрэгжилт

 **1080**
ЦАГ



Гадаад сургалт

68.8%



Дотоод сургалт

32.2%



УЛАМЖЛАЛТ ӨДӨРЛӨГҮҮД



Жил бүр ажилтнуудынхаа эрүүл мэнд, эв нэгдлийг дэмжих зорилгоор Ти Эм Эл группийн хэмжээнд 5 төрөлт спорт өдөрлөгийг зохион байгуулсан. Мөн уламжлал болгон 5 сарын 13-ны өдрийг “Өнөөдрийн мод – Маргаашийн ногоон ертөнц” уриан дор 1000 ширхэг мод тарьж хүчил төрөгч үйлдвэрлэхэд хувь нэмэр оруулж экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад хөрөнгө оруулалт хийсэн.

АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРЛӨХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ

АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ



Жил бүр ажилчдаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэгт тогтмол хамруулдаг.

ЭРҮҮЛ АЖИЛТАН ХӨТӨЛБӨР



Жилийн турш 7 хоногт 2 удаа нийт ажилчдын эрүүл мэндийг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бариа засалд хамруулдаг.

АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ ЦУС ХАНДИВЛАХ АЯН



Жил бүр ажилтнууд маань сайн дураар цусаа хандивладаг. 145 ажилтан 50 литр цус хандивлаж, нийгэмд эерэг хувь нэмэр оруулсан.

АЖИЛЧДЫН ХАРИЛЦАН ДЭМЖЛЭГИЙН ХӨТӨЛБӨР



Талархлын соёлыг бий болгохоор өдөрлөг зохион байгуулав.



ЗАСАГЛАЛ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ



Компанийн бүтэц олон нийтэд нээлттэй веб сайтад байршилтай байдаг.



Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал тогтмол хуралдаж шийдвэрээ нээлттэй мэдээлдэг.



Компанийн үйл ажиллагааны олон Санхүүгийн тайланг тайлагнасан.



Бид бүх мэдээ, мэдээллийг байгууллагын албан ёсны вэбсайт, хөрөнгийн биржийн портал гол эх сурвалжийн сувгаар, ил тод байдлаар нээлттэйгээр нийтэлдэг.

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

"Монголын Хөрөнгийн бирж" ХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1 дүгээр хавсралт

Энэхүү тайлан нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудын байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн стратеги, арга хэмжээ, нөхцөл байдлыг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд ил тод нээлттэй тайлагнах зорилготой.

Хэсэг 1, 2, 3 нь нийт үнэт цаас гаргагч компаниудад хамааралтай бөгөөд Хэсэг 4 нь зөвхөн тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас гаргагчдад хамаарна.

Хэрэв тайлангийн маягтад заасан аливаа мэдээллийг цуглуулах, тайлагнах боломжгүй бол тайлагнах боломжтой талаарх тайлбар, цаашид мэдээллийг тайлагнах чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар 'тайлбар' хэсэгт бичнэ үү.

Огноо (он, сар, өдөр):	2025.04.15
Үнэт цаас гаргагчийн нэр:	Эм Жи Эл Акуа ХК
Үнэт цаасны нэр, код (МХБ симбол):	MGLA
Салбарын ангилал:	Савласан цэвэр ус үйлдвэрлэл худалдаа
Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	Эм Жи Эл Акуа ХК
Тайлангийн хамрах хугацаа:	2024.01.01-12.31
Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас:	БОНЗ Б.Ариунжаргал eeo_audit@mglacqua.mn 85707070
Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):	Гүйцэтгэх захирал Х.Төгшээ
Гүйцэтгэх удирдлагын гарын үсэг:	

Бүлэг	Шалгуур үзүүлэлт	Үзүүлэлт (өмнөх он)	Үзүүлэлт (тайлант он)	Хэмжих нэгж	Нэмэлт мэдээлэл	Тайлбар	Холбоос
Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд							
MS1.1	Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Тийм		Тогтвортой хөгжилд нийцсэн бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэл явуулж, ажилтнууддаа эрүүл, тэгш хүртээмжтэй ажиллах орчныг бүрдүүлэх, нийгмийн хөгжлийг дэмжих, харилцагч, ханган нийлүүлэгч, хөрөнгө оруулагчдаа дэмжих байдлаар тогтвортой хөгжлийн зорилгуудыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Тийм			мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 103, ISO 14001
MS2.2		Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Тийм			мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 103, ISO 14001
MS3.1		ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм			мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102
MS3.2		Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм			мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102
MS3.3		Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм			мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102
MS3.4		Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?	Тийм			мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102
MS3.5	Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Тийм		"Эм Жи Эл Акуа" ХК-ын цар хүрээ, тоног төхөөрөмж, түүхий эд материал, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хуулийн хугацаанд гүйцэтгэдэг бөгөөд 2024 онд "Гурван орчил мандат" ХХК гүйцэтгүүлж байна.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SASB
MS4.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Чадварх бүрдүүлэлт		5	цаг	Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, гамшгийн эрсдэлийг даван туулах, нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжих, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, зөвлөгөө, мэдээллээр хангаад байна.	⁴ GRI 102

MS4.2		Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?		Тийм		Тогтвортой хөгжлийн бодлого 2030, 2050 уялдуулан "Эм Жи Эл Агуа" ХК -ын тогтвортой хөгжлийн бодлого, үйл ажиллагаа комплайнс, цар хүрээг хамран хяналт хийж сайжруулан ажиллаж байна.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, SDG 12
MS4.3					Тийм		Жилд 2 удаа ТУЗ-ын тайлан болон дотооддоо тайлагнан ажилладаг.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, SDG 12
MS5.1		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?		Тийм		НҮБ, Монголын тогтвортой санхүүгийн холбоо, Санхүүгийн зохицуулах холбоо, Тогтвортой хөгжлийн олон улсын байгууллага хамтран гаргасан БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийн дагуу тайлагнан ажилладаг.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, SDG 12
MS5.3		Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?		Тийм		People in Need, ToC Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо, Хөгжлийн шийдэл, Caritas Crech Republic, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, БО тогтвортой хөгжил судлалын төв зэрэг маш олон байгууллагатай хамтарч "Эдийн засгийн ногоон шилжилт" төслийн хүрээнд ISO 14020 Тэмдэг, мэдэгдэл боловсруулах стандарт нэвтрүүлэхээр зорин хамтран ажиллаж байна.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, SDG 17
MS6.1	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд								
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал		3,263,678	Mera Втц	600 Mera Втц, 800 Mera Втц 2 дэд станцаар эрчим хүч хэрэглэн ашиглаж байна.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 302, SDG 12
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)		834,180,373 ₮	Mera Втц '000	Үйл ажиллагаандаа хөрөнгө оруулалт хийж байгаль орчин, хүрээлэн буй орчин бага сөрөг нөлөөтэй усан халаалттай уурын зуух ашиглалтад оруулснаар нэмэлтээр цахилгаан халаагуур хэрэглэлгүй эрчим хүчийг 10% хэмнээд байна.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 302, SDG 12
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)		56,727,272 ₮	BTU & % Гкал	Бүх объектын дулаан алдагдлыг багасгаж Оффис, үйлдвэрийн барилгын гадна засвар үйлчилгээ оруулсан.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 302, SDG 12
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)		485,675,639 ₮	Литр/кг & %, ГЖоуль, Төгрөг	Үйл ажиллагаандаа шинэ усан халаалттай уурын зуухыг ашиглалтад оруулж бага түлшээр их м2 халааснаар өмнөх оноос түлшний хэрэглээгээ 5% хувиар бууруулсан.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 302, SDG 12
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь			100% Нүүрс	Компанийн бүх объектыг сайжруулсан түлшээр 100% халааж байна.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SFRD
E2.1		3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн		12229.9	CO2/тонн	"Эдийн засгийн ногоон шилжилт" (СОГЭ) төслийн Байгаль орчин, Тогтвортой хөгжил судлалын төвтэй хамтран Монгол Улсад анх удаа хүнсний салбарын үйлдвэрт "Хүлэмжийн хийн тооллого" манай "Эм Жи Эл Агуа" ХК хийлгэсэн. Хүлэмжийн хийн тооллогын протоколын сайжруулсан хувилбарыг түлхүү аргачлалдаа ашигласан. ХүХ-ийн протоколд суурилсан АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг (EPA)-с ХүХ ялгаруулдаг байгууллагуудын жилийн туршид ялгаруулах ХХЯ-ыг тооцоолоход нь туслах зорилгоор боловсруулсан "ХХЯ-ын хялбаршуулсан тооцоолуур"-ыг ашиглан гаргасан.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.

E2.2	Хүлэмжийн хийн ялгарал	3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бүс үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	12229.9	CO2/тонн	Хүлэмжийн хийн тооллого хийхдээ 3 хүрээлээр хуваан гаргасан. Хүрээ 1,2 Үйлдвэрлэл, хадгалалт, Үйлдвэрийн явцаас гарах эрчим хүчний хэрэглээ. Хүрээ 3 Түүхий эд, түүхий эд боловсруулалт, түгээлт, жижиглэн худалдаа, сав баглаа боодлын хаягдал зэрэг бүхий л талыг хамарч боловсруулсан. Мөн хуулийн нийцлийн хүрээнд хийгдсэн судалгаа шинжилгээний зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Ирэх жилд ХХТ тооллого ахин хийлгэх үр дүнгийн нь хэмжүүлж харьцуулахаар ажиллаж байна.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт)бууралт		CO2/тонн	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн мөн хүлэмжийн хийн ялгарлын тайлант онд 850 гаруй хайлаас, гацуур мод нэмж тарьж, усалгаа, арчилгааг хийлээ.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Тийм		Тогтвортой хөгжлийн бодлого зорилтын хүрээнд үйл ажиллагаандаа хуулийн нийцлийг хангуулж Байгаль орчны Аудитын зөвлөмж, Хүлэмжийн хийн ялгарлыг тоолсон тооцоолол, зөвлөмжийг үндэслэн шат дараатай арга хэмжээ төлөвлөд бодлого чиглэлдээ тусгаж ажиллаж байна.		GRI 201, TCFD, SDG 13
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү?(сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Тийм		Олон улсын (СОГЭ) төслийн багийнхантай хамтарч судалгаа шинжилгээний ажлаар хамтраад 3 жил болж байна ирэх жилийн БОНЗ тайлагналдаа эцэслэн тусгагдахаар судалгааны ажил 80% тай явж байна.		GRI 201, TCFD, SDG 13
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	0	Төгрөг		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 201, TCFD, SDG 13
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	18.216.000	Төгрөг	Үер, ус, гал бусад гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор Бүх объект эд хөрөнгийг "Тэнгэр даатгалд" даатгуулсан.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 201, TCFD, SDG 13
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга			Олон улсын (СОГЭ) төслийн багийнхантай хамтарч судалгаа шинжилгээний ажлаар хамтраад 3 жил болж байна ирэх жилийн БОНЗ тайлагналдаа эцэслэн тусгагдахаар судалгааны ажил 80% тай явж байна.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI, SASB, World Economic Forum
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	76,806.75	м3/Л	Ашигласан 1м3	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 303, SDG 6
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	898	тонн	Компанийн ахуйн хог хаягдлын хэмжээ 898 тонн	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 306, SDG 12
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	30	%	Хаягдал хуванцар 8 тонн, Хаягдал гялгар 8.9 тонн, Хуванцар бөглөө 1.3 тонн	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 306, SDG 12
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	3	%	Үйлдвэрийн гадна орчны ногоон байгууламж	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 304, SDG 15
Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд								
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	56%	%	Барилга, уул уурхайн салбарын үйл ажиллагаа 4-10 саруудад идэвхиждэгтэй холбоотой Түгээлтийн албаны ажилтнуудын шилжилт хөдөлгөөн ихэсдэг тул хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр ЗХНА-аас тухайн саруудад идэвхижүүлэлтийн төлөвлөгөө гарган ажилласан.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 401, SDG 8
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	13	Тоо	Маркетингийн албанд 3 ажилтан, Ерөнхий менежер 1, Аж ахуйн албанд 9 ажилтны шинэ орон тоо бий болгосон.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 401, SDG 8
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	6	цаг	Гаднаад сургалт - 22 удаагийн 990 цагийн сургалт, Дотоод сургалт - 9 удаагийн 1080 цагийн сургалтыг зохион байгуулсан.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 401, SDG 8
S2.1		ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэгсэн)?	Тийм		Хавсралтаар		GRI 103, SDG 10

S2.2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	0	%	Хандлага сургалт, ХАБЭА Урьдчилан зааварчилгааны сургалт, ажлын бүх мөст дээр эрсдэлийн үнэлгээ хийдэг, ажлын хувцас нэг бүрийн хамгаалах хэрэгслийн зөв хэрэглэх ашиглах дадал хэвшил суулгах зөвлөмжүүд өгдөг. Нийт ажилчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулдаг.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 403, SDG 3
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	5	цаг	Урьдчилан зааварчилгааны сургалт 2 цаг, Нийт ажилтны сургалт 2 цаг, Намалтээр Галын бүлгэм, ГОХХСБК орвол журмын 1 цаг.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 403, SDG 3
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	138	хүн	Мөнгөн гүүр эмнэлэгт ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэгт хамруулсан. Биеийн ерөнхий индекс аппарат: Артерийн даралт, зүрхний цохилт, дотор өөхжилт. Лобараторийн шинжилгээ: Цус, шээсний дэлгэрэнгүй шинжилгээ, элэг, бөөр, нойр булчирхайн үйл ажиллагаа, Хеликобактер, өвх тосны сопилцоо, чихрийн шижин, эрдэс бодисын шинжилгээ. Багажийн шинжилгээ: Зүрхний цахилгаан бичиг, эхо Жил бүр 190-200 ажилтанг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулахаас гадна ажлын байранд мэргэжлийн бариа засалч нар тогтмол ажиллуулж ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж байна.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 403, SDG 3
S3.1	Эрх тэгш байдал	Жендэрийн бодлого, журам	Жендэрийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?			Олон янз байдал тэгш боломжийн бодлого тусгайлан (жендерийн тэгш байдал, нас, үндэс, угсаа, хөгжлийн бэрхшээл шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, Удирдлагын түвшинд хүртэл тэгш оролцоог хангах) багцалсан бодлого боловсруулж байна.	Гүйцэтгэх захирлын А/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна.4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	GRI 405, SDG 5
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?				Гүйцэтгэх захирлын А/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна.4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	GRI 103, SDG 5
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?				Гүйцэтгэх захирлын А/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна.4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	GRI 103,SDG 10
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	66% эрэгтэй34% эмэгтэй	%	Нийт ажилчидын125 эрэгтэй, 80 ажилчид эмэгтэй	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 405, SDG 5
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	8 эрэгтэй,1 эмэгтэй	%	8 эрэгтэй,1 эмэгтэй	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 405, SDG 5
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	5 эрэгтэй, 4 эмэгтэй	%	Нийт дундаж ажилтны тоо 205, Эрэгтэй 125, Эмэгтэй 80. Эм Жи Эл Акуа ХК-ийн ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны хөдөлмөр эрхлэлтийн бодлогуудад жендер болон эрх тэгш байдал, хүртээмжит байдал, олон янзат байдлыг тусган хэрэгжүүлж байна.174:J74 Тайлант онд 205 ажлын байрыг бий болгон, өрсөлдөхүйц цалин урамшууллыг бий болгож ажиллав. Үүнд эрэгтэй 130, эмэгтэй 80 ажилтан. Тусгай хэрэгцээт болон тэтгэврийн насны иргэдийн эрх тэгш ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор онцлог, ялгаатай байдалд нь тохирсон ажлын байр бий болгон ажиллалаа.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 405, SDG 5
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	60% эрэгтэй /40% эмэгтэй	%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 405, SDG 5
S3.8		Жендэрт суурилсан цалингийн	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн	2,500,000	Tenget	Эмэгтэй 2.200.000, Эрэгтэй 2.500.000	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 405, SDG 5, SFRD

S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэгсэн)?				Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн журмын заалтаар зохицуулагдсан байдаг ч тусгайлан (Олон тапт оролцогч талуудтай хамтран ажиллах бодлого) боловсруулж байна.	Гүйцэтгэх захирлын /А/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна.4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	SDG 10
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь		4	%	Эм Жи Эл Агуа ХК-д хөгжлийн бэрхшээлтэй 8 ажилтан тогтмол ажилладаг бөгөөд нийт ажилтнуудын 4%-ийг эзэлж байна.		SDG 10
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу		Үгүй			мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 10
S4.4		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагах мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо		500.000	Төгрөг	ийвчилсан үнэлгээ гараагүй, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан. "Нийслэлийн байгаль орчны газарт"	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 10
SS.1		Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?				(Олон тапт оролцогч талуудтай хамтран ажиллах бодлого) боловсруулж байна.	Гүйцэтгэх захирлын /А/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна.4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	IFC
SS.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)		үгүй		Боловсруулж байна 2025 оны хагас жилийн тайланд хавсаргана	Гүйцэтгэх захирлын /А/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна.4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	IFC Performance Standards
SS.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?		Тийм		Бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг "Санал гомдол шийдвэрлэх" журмын дагуу шийдвэрлэж хэрэглэгч харилцагчдад сэтгэл ханамжтай үйлчилгээ авах боломжоор хангаж ажилладаг.	Хавсралтаар	
SS.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?		Тийм		Дүүрэг, хороотойгоо уялдаа холбоотой ажиллаж хамтран ажилладаг. Компанийн албан ёсны харилцах суваг болох 77045555, www.mglaqua.mn, info@mglaqua.mn, Voyage Mongolia фэйсбүүк хуудсаар дамжуулан санал, гомдол, хүсэлтийг хүлээн авч тухай бүр шийдвэрлэдэг.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	IFC Performance Standards

SS.6	Нийгмийн хариуцлага ба ил тод байдал						Эм Жи Эл Акуа ХК нь компанийн нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин гэсэн 3 чиглэлийг нэн тэргүүнд авч үздэг бөгөөд тайлант онд дараах ажлуудыг хэрэгжүүллээ. 1. Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгох, дэмжих зорилгоор уул "Хамтдаа алхацгаа клуб НҮТББ"-н гишүүдийг БНХАУ, ӨМӨЗО, Далан хар уулын Монгол Хятад хоёр улсын анхдугаар хамтарсан алхалт хийхэд дэмжлэг үзүүлэв. 2. Монгол Улсын эрүүл мэндийн салбарын оюутан залуусыг олон талт боломжоор хангах, ирээдүйн чадварлаг мэргэжилтэн бэлтгэх зорилгоор "Med Plus Эрүүл мэндийн мэргэжилтний хөгжлийн хурдасгуур НҮТББ"-тай хамтран ажиллав. Хамтын ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй оюутан залуус болон залуу эмч нарыг эрүүл мэндийн салбартаа түүчээлэх, мэргэжлийн үнэ цэнээ ойлгох, цаашид нарийн мэргэжил эзэмшин суралцахад чиглүүлэх болон тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжуудыг нээн, оюутан байх хугацаандаа эзэмшвэл зохих дадал, хувь хүний төлөвшил, хандлагыг сайжруулахаар "Эрүүл мэндийн манлайллын хөтөлбөр"-ийг дэмжиж ажиллав. 3. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тайлант онд 850 гаруй хайлаас, гацуур мод нэмж тарьж, усалгаа, арчилгааг хийлээ. 4. "Байртай бөглөө" хөтөлбөрөөр дамжуулан уусан усныхаа бөглөөг цуглуулах зорилгод хэрэглэгчдийг нэгтгэж хуванцар бөглөө байгальд хаягдахаас урьдчилан сэргийлж, 1.3 тонн бөглөө буцаан цуглуулан хэрэглэгчдийг хуванцар хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулалтад хувь нэмэр оруулахыг уриалав. Түүнчлэн тус хөтөлбөрийн супер бэлгийн хоёр азтан тус бүрт хоёр өрөө байр бэлэглэж, агаарын бохирдлын эсрэг хувь нэмрээ оруулахаар зорьсон.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 413, SDG 8
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжыг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		Үгүй		Тушаал хавсаргав	Гүйцэтгэх захирлын А/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна. 4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	GRI 204, SDG 8
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь		95%	%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 204, SDG 8
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь		0	%	Тогтвортой аргаар нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 204, SDG 8
Засаглалын шалгуур үзүүлэлтүүд									
G1.1	Авилгал болон ёс зүй	Авилгал, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авилгын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?		тийм		Тушаал хавсаргав	Гүйцэтгэх захирлын А/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна. 4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	GRI 205, SDG 16
G2.1	Компанийн засаглал	Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь		33.30%	%	Нийт 9 гишүүдээс Хараат бус 3 гишүүнтэй	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.2		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?		тийм		ТУЗ боловсруулж байна.	ТУЗ-аас журмын төсөл боловсруулж байна. 2025 оны 3 улиралд батална.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.3		Компанийн засаглалын бодлого, журам	Компанийн засаглалын бодлого, журам бий юу?		тийм		ТУЗ боловсруулж байна.	ТУЗ-аас журмын төсөл боловсруулж байна. 2025 оны 3 улиралд батална.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.1	Комплайнс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?		тийм		Боловсруулж байна. 2025 оны 2-р улирлын тайланд хавсаргах.	Гүйцэтгэх захирлын А/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна. 4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16

G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?		тийм		Боловсруулж байна. 2025 оны 2-р улирлын тайланд хавсаргах.	Гүйцэтгэх захирлын /A/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна.4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү)									
FS1	Санхүүгийн үйлчилгээ	Санхүүгийн хүртээмж	Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр		55	хүн	Түгээлтийн алба шинэ түгээгч нарт (Төлбөр тооцооны сургалт) орсон.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 1
A1	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Устгалын бодис	Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?		Үгүй		Тушаал хавсаргав	Гүйцэтгэх захирлын /A/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна.4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	GRI 403, SDG 12
A3		Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь		3729 ш	0.01%	Чанарын шаардлага хангаагүй буцаалтаар орж ирсэн акталсан бүтээгдэхүүний хувь	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 416, SDG 12
T2		Тогтвортой аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн	Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандартын (MNS 6926:2021) дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо, эзлэх хувь		25.152.066	сая, ширхэг	Тохирлын гэрчилгээ сунгагдсан	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 416, SDG 12
T3		Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам		тийм		Тушаал хавсаргав	Гүйцэтгэх захирлын /A/10 тоот тушаалын дагуу боловсруулж байна.4 сарын 18 нд олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулна.	GRI 403, SDG 12
MA2		Дахин боловсруулсан материал	Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь		40	%	Эм Жи Эл Акуа ХК нь үйл ажиллагааны явцад үүссэн хог хаягдлыг байгаль орчинд эзлтэй байдлаар шийдвэрлэх зорилтын хүрээнд зориулалтын дахин боловсруулах үйлдвэрүүдэд тогтмол нийлүүлдэг. 2024 онд манай компани нийт 8.9 тонн гялгар уутны хаягдал, мөн 8 тонн хуванцар хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн байна. Мөн "Байртай бөглөө" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хэрэглэгчдийг уусан усныхаа хуванцар бөглөөг цуглуулах үйлсэд нэгтгэснээр байгальд хаягдах эрсдэлтэй 1.3 тонн хуванцар бөглөөг буцаан цуглуулжээ. Энэ хөтөлбөр нь хэрэглэгчдийг хуванцар хог хаягдлаа ангилан ялгах, дахин боловсруулалтад хувь нэмэр оруулах ухамсар, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн юм.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 12
MA3		Ногоон шошго, гэрчилгээжүүлэлт	Эко буюу ногоон шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний эзлэх хувь		0	%	People in Need, ToC Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо, Хөгжлийн шийдэл, Caritas Czech Republic, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, БО тогтвортой хөгжил судлалын төв, Монголын стандарт хэмжил зүйн төв зэрэг маш олон байгууллагатай 2022 оноос хойш хамтарч "Эдийн засгийн ногоон шилжилт" төслийн хүрээнд ISO 14020 Эко тэмдэг, мэдэгдэл боловсруулах стандарт нэвтрүүлэхээр зорин хамтран ажиллаж байна.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 417, SDG 12